



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ХЯРГАС НУУР-ЗАВХАН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 1/13

Улиастай

Ус ашиглах зөвшөөрөл
олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29 дүгээр зүйлийн 29.1, Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2023 оны 05 сарын 17-ны өдрийн 107 тоот ус ашиглуулах дүгнэлт, "Форс Голд Майнинг" ХХК-ны 2023 оны 06 сарын 05-ны өдрийн 13 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Завхан аймгийн Ургамал суманд орших MV-020628 тоот тусгай зөвшөөрөл бүхий "Форс Голд Майнинг" ХХК-нд 2023 онд ажилчдын унд ахуйн хэрэгцээнд 2,448.0 м³/жил, технологийн хэрэгцээнд 87,040.0 м³/жил, зам талбайн тоосжилт дарахад 11,064.0 м³/жил, биологийн нөхөн сэргээлт, мод тарьж ургуулах усалгаанд 2,295.0 м³/жил, ерөмдлөгийн ажилд 362. м³/жил ус ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. "Форс Голд Майнинг" ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулахыг Усны барилга байгууламж, үйлдвэр хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Отгонбилэг)-д даалгасугай.

3. Дараах арга хэмжээг авч ажиллахыг ус ашиглагч "Форс Голд Майнинг" ХХК-ны гүйцэтгэх захирал /Д.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3.1 Ахуйн бохир усыг "Хаягдал ус, Ерөнхий шаардлага" MNS4943:2015 стандартын шаардлагад нийцүүлэн байгальд нийлүүлэх;


3.2 Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллах;

3.3 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаалаар батлагдсан "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ын хэрэгжилтийг хангах;


3.4 Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийг хэрэгжүүлж, ус ашиглалтын тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнаж байх;

4.Энэхүү тушаал болон ус ашиглах гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах мэргэжилтэн (Т.Даваажаргал)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЗОЛ-ОД



Батлав
Хяргас нуур - Завхан голын сав
газрын захиргааны дарга
Э. Зол-Од



Батлав
Форс Голд Майнинг ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Д. Ганбаатар

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 06 сарын
08-ны өдөр

Дугаар 05

Завхан аймаг,
Улиастай сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29.1-д -д заасны дагуу Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 107 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны даргын 2023 оны 06 дугаар сарын 08 -ний өдрийн А/13 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Хяргас нуур – Завхан голын сав газрын захиргааны Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн, ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Цаваандорж овогтой Отгонбилэг,

Ус ашиглагчийг төлөөлж: Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 7-р хороолол, Шинэ дэлхий телевизийн байр 803 тоотод байрлах Форс Голд Майнинг ХХК (Улсын бүртгэлийн дугаар 9011622079, Регистрийн дугаар 6088759)–ийн гүйцэтгэх захирал Давааноров овогтой Ганбаатар нар Завхан аймгийн Дөрвөлжин сумын гадаргын ус Завхан голоос, мөн Завхан аймгийн Ургамал сумын Цагаан толгой ордын газрын доорх усыг ашиглах талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 2023 оны 12-р сарын 31-н хүртэлх хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Ажиллагсдын унд ахуй болон үйлдвэрлэлийн технологийн усны хэрэгцээнд;

2.2. Ашиглах усны хэмжээ: нийт 102,847.0 м³/жил

2.2.1 Технологийн ус 87,040.0 м³

2.2.2 Биологийн нөхөн сэргээлтэнд 720.0 м³

2.2.3 Унд ахуйн хэрэгцээ 2,448.0 м³

2.2.4 Зам талбайн тоосжилт дарах 11,064.0 м³

2.2.5 Тэрбум мод усалгаа 1,575.0 м³

2.2.6 Өрөмдлөгт ашиглах ус 362.0 м³

2.2.7. Форс Голд Майнинг ХХК-ийн 2023 онд 16,169.0 м³ усыг газрын доорх өрөмдмөл худгуудаас, 87,040.0 м³ гадаргын усыг авч ашиглана.

| | |
|---|-------------------------------|
| $80.0 \text{ м}^3/\text{цаг} \times 20 \text{ цаг}/\text{хон} = 1,600.0 \text{ м}^3/\text{хон}$ | Хоногт угаах элсний хэмжээ |
| $1,600.0 \times 4.0 \text{ м}^3 = 6,400 \text{ м}^3/\text{хон}$ | Хоногт шаардагдах усны хэмжээ |

| | |
|---|---|
| $6400 \text{ м}^3/\text{хон} \times 5 \text{ хон} = 32,000.0 \text{ м}^3$ | Эргэлтийн усан санд тогтмол байлгах усны хэмжээ |
| $68,000.0 \text{ м}^3 : 1,600.0 \text{ м}^3/\text{хон} = 43 \text{ хон}$ | Хүдэр баяжуулахад ажиллах хугацаа |
| $6,400.0 \text{ м}^3/\text{хон} \times 0.2 \times 43 \text{ хон} = 55040 \text{ м}^3$ | Ууршилт шүүрэлтээр алдагдах усны хэмжээ |
| $32,000.0 \text{ м}^3 + 55040 \text{ м}^3 = 87,040.0 \text{ м}^3$ | Нөхөн сэлбэлтээр авах ус |
| $3,500 \text{ ш мод} \times 45 \text{ л/ш} \times 10 \text{ удаа} = 1,575.0 \text{ м}^3$ | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийн хүрээнд мод тарихад ашиглах ус |
| $20,000 \text{ м}^2 \times 4 \text{ л/м}^2 \times 9 \text{ удаа} = 720.0 \text{ м}^3$ | Биологийн нөхөн сэргээлт хийхэд шаардагдах усны хэмжээ |
| $46,100.0 \text{ м} \times 2.0 \text{ л/м}^2 \times 120 \text{ хон} = 11,064.0 \text{ м}^3$ | Зам талбайн тоосжилт дарах ашиглах ус |
| $87,040.0 \text{ м}^3 + 11,064.0 \text{ м}^3 + 1,575.0 \text{ м}^3 + 720.0 \text{ м}^3 = 100,399 \text{ м}^3$ | Нийт ашиглах ус |

Унд ахуйн усны нийт хэрэгцээнд:

$136 \text{ хүн} \times 150 \text{ л/хон} \times 120 \text{ хон} = 2,448.0 \text{ м}^3$

Эрэл хайгуулын өрөмдлөгт ашиглах усны хэмжээ:

1. Шууд угаалгатай өрөмдлөг, 89мм голчтой

Эрэл хайгуулын өрөмдлөгт шаардагдах ус (Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтын 2.1 тооцов).
 $2100 \text{ т/м жил} \times 10 \text{ м}^3 : 100 \text{ т/м} = 210 \text{ м}^3/\text{жил}$

2. Шавар уусмалаар цооног цэвэрлэх.

Цүүцний голч 125тг хүртэл т/м бол $7,3\text{м}^3$ усыг нэг цооног цэвэрлэхэд

зарцуулна.

(Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах

усны норм батлах тухай Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын

2015 оны А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтын 2.2-р тооцов)

$2100 \text{ т.м} \times 7,3\text{м}^3 : 125\text{мм} = 122.64 \text{ м}^3/\text{жил}$

3. Цооногийн бэхэлгээний яндангийн голч 219 мм.

(Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.4-р тооцов).

$2100 \text{ т.м/жил} \times 0.14 : 10\text{м} = 29.4 \text{ м}^3/\text{жил}$.

Эрэл хайгуулын өрөмдлөгт ашиглах нийт усны хэмжээ:

$210 \text{ м}^3 + 122.64 \text{ м}^3 + 29.4 \text{ м}^3 = 362.04 \text{ м}^3/\text{жил}$

| № | Худгийн нэр | Х | У | Ундарга л/с |
|---|-------------|-------------|-------------|-------------|
| 1 | Худаг 1 | 93 58 20.06 | 48 25 52.06 | 8 |
| 2 | Худаг 2 | 93 58 13.33 | 48 25 50.31 | 8 |
| 3 | Худаг 3 | 93 58 34.15 | 48 25 54.66 | 5 |

2.2.7. үйлчилгээ, мЗ/жил

Хамааралгүй

2.2.8. эмчилгээ, сувилгаа, хүн/жил

Хамааралгүй

2.3. Усны чанар, найрлага: Уурхайн олборлолтын талбайд байгаа ашиглалтын худгуудын усны чанарын шинжилгээг улирал бүр хийлгэж, дүнг улирал бүр-Хяргас нуур Завхан голын сав газрын захиргаанд ирүүлэх.

2.4. Усны эх үүсвэр

2.4.1. Цагаан толгойн ордын ашиглалтын 3 гүний цооногос хоногт 134,7м³ хэмжээтэйгээр авч ашиглана. Үүнд: Зам талбайн тоосжилт дарах зорилтоор 11,064.0 м³, унд ахуйн хэрэгцээ 2,448.0м³, ногоон байгууламж, мод тарих усалгаанд 2,295.0 м³, хайгуулын өрөмдлөг 362 м³ нийт 16,169,0 м³ ус.

2.4.2. Завхан голоос технологид хэрэглэх 87,040.0 м³ усыг авч ашиглана. Форс Голд Майнинг ХХК-н өөрийн хөрөнгөөр бий болгосон 3 гүний худгийн 2018 онд хийсэн шавхалт, туршилтын ажлыг үр дүнгээр ашиглах боломжит усны нөөц хүрэлцэхгүй муу бөгөөд 3 цооног нийт 172.04 м³/ хоног буюу 172042 литр ус ашиглах боломжтой гэж тогтоосон.

Байршил:

- Ургамал сумын Тосгуур багийн Ханын худаг орчим Цагаан толгой ордын гүний усны 3 ширхэг худаг (Худаг 1, 2, 3)
- Дөрвөлжин сумын Таван толгой баг Завхан голоос гадаргын ус ашиглана. 93 49 96.68 48 29 52.37 цэгээс.

Барилга байгууламж: Өрөмдмөл худаг

Тоног төхөөрөмжийн нэр, **Худаг 1**

марк: Барилгагүй, Submersible маркын насос суурилуулсан, тоолууртай

Тоног төхөөрөмжийн нэр, **Худаг 2**

марк: Барилгагүй, Submersible маркын насос суурилуулсан, тоолууртай

Тоног төхөөрөмжийн нэр, **Худаг 3**

марк: Барилгагүй, Submersible маркын насос суурилуулсан, тоолууртай

2.5. Хаягдал ус:

Хэмжээ: Унд ахуйн хэрэгцээнд нормоор тооцоход жилд 2,448.0 м³ ус хэрэглэж, хэрэглээнээс гарсан ахуйн бохир усыг бага оврын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэн ашиглана.

2.5.1. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

2.6. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

Технологи

Цэвэрлэгээний түвшин Механик болон биологийн арга Дахин ашиглах цэвэрлэсэн ус MNS 6734:2018 стандартын шаардлагыг

Загвар:
Тоолуурын тоо: 1
Суурилуулсан байгууллага:
огноо:
Баталгаажуулсан байгууллага: Стандарт, хэмжил зүйн газар
огноо:
Тоолуурын заалт: 000000 м³
(2023 оны 06 дугаар сарын 08-ний
байдлаар)

2.9. Ургамал сумын байгаль хамгаалагч, БОХУ-ын байцаагч болон Сав газрын захиргаа, Форс Голд майнинг ХХК-ийн мэргэжилтэн нарыг байлцуулан цэвэр усны тоолуурын заалтыг 12 дугаар сарын 31-ний байдлаар дуусгавар болгон баталгаажуулж, дараа оны 1 дугаар сарын 1-ээс хойших заалтыг тайлант оны ус ашиглалтын мэдээнд оруулж байх.

2.10. Ус ашиглах гэрээний дуусах хугацааг 12-р сарын 31-ны өдрөөр дуусгавар болгож, дараа оны 1-р улиралд багтаан зөвшөөрөл, гэрээ дүгнэлтээ гаргуулсан байна.

2.11. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх, хайс хашлага тэмдэгжүүлэлтийн бүрэн бүтэн байдлыг хангах.

2.12. Ууршилтаар алдагдах усны алдагдлыг багасгах арга хэмжээ авч ажиллах

2.13. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

2.13.1. Технологийн усны хэрэглээ:

$$1675 \times 1 = 1675 \text{ /Гадаргын усны итгэлцүүр/}$$

$$87040 \times 1675 = 145,792,000 \text{ ₮}$$

$$145,792,000 \times 0.25 = 36,448,000 \text{ ₮}$$

2.13.2. Биологийн нөхөн сэргээлт

$$2716 \times 0.1 = 271.6 \text{ /Газрын доорх усны итгэлцүүр/}$$

$$2,295.0 \text{ м}^3 \times 271.6 = 623,322 \text{ ₮}$$

$$623322 \text{ ₮} \times 0.25 = 155,830.5 \text{ ₮}$$

2.13.3. Зам талбайн тоосжилт

$$2716 \times 0.2 = 543.2 \text{ /Газрын доорх усны итгэлцүүр/}$$

$$11,064 \text{ м}^3 \times 543.2 = 6,009,964.8 \text{ ₮}$$

$$6,009,964.8 \text{ ₮} \times 0.3 = 1,802,989.44 \text{ ₮}$$

2.13.4. Өрөмдлөгт ашиглах ус

$$2716 \times 1.7 = 4,617.2 \text{ /Газрын доорх усны итгэлцүүр/}$$

$$362.04 \text{ м}^3 \times 4617.2 = 1,671,611.09 \text{ ₮}$$

$$1,671,611.09 \text{ ₮} \times 0.2 = 334,322.2 \text{ ₮}$$

Нийт төлбөр:

$$36,448,000 + 155,830.5 + 1,802,989.4 + 334,322.2 = \mathbf{38,741,142.1 \text{ төг}}$$

/ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ/

а. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу унд ахуйд жилд ашиглах **2,448.0 м³**/жил усыг төлбөрөөс чөлөөлнө.

б. Ашиглалтын худгуудаас авч байгаа гүний ус ашигласан төлбөр болон гадаргын уснаас ашигласан төлбөрийг Завхан аймгийн Төрийн сангийн 1165117377 тоот дансанд төвлөрүүлэх

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

- 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
 - 4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
 - 4.5.2. аль нэг тал татан буугдсан бол.
 - 4.5.3. ус ашиглагчийн үүрэг болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;
 - 4.5.4. байгаль орчныг хамгаалах тухай болон усны тухай хууль тогтоомж зөрчсөн;
 - 4.5.5. ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөөгүй;
 - 4.5.6. усны эх үүсвэрийг бохирдуулсан;
 - 4.5.7. усны тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмж суурилуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;
 - 4.5.8. сав газрын захиргааны шийдвэрээр;
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

.....
Отгонбилэг

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Цаваандорж овогтой Отгонбилэг

Харилцах утас: 89098282

Ус ашиглагчийг төлөөлж:

.....
Дандал

Форс Голд Майнинг ХХК-ийн Ерөнхий геологич Дандар овогтой Содном

Харилцах утас: 88106854